

## ТҮҮХ, ЭДИЙН ЗАСАГ

Ш. Бира  
Н. Ишжамц  
Ш. Сандаг

**МАОГИЙНХНААС БНМАУ-ЫН ТҮҮХИЙГ ХЭРХЭН  
ГУЙВУУЛЖ БАЙГААГ ШҮҮМЖЛЭХ НЬ  
(Үргэлжлэл)**

**2. Монголын нутаг дэвсгэр дээрх эртний  
аймгууд ба Хятад**

Хятад төвийн номлолоор ахул, «умардын бүдүүлгүүдийн» тоонд оруулдаг монгол, түрэг, түнгүүс ард түмэн биеэ даан хөгжиж өөрийн улс төрөө байгуулах чадваргүй байсан мэт болж байна. Иймд хятадын маоист түүхчид эдгээр ард түмнийг Хятадаас «хараат», хятадын эзэн хаадад алба баригчид байсан төдий үздэг юм.

Маоист түүхчид Монголын нутаг дэвсгэр дээр эрт үеэс оршин амьдарч ирсэн Хүннү нарын түүхийг «хянан өөрчлөхийг» оролдож байна. Сүүлийн үед энэ сэдвээр Хятадад цөөнгүй зохиол хэвлэгдэж энэхүү эртний аймгийн түүхийг Хятадын түүхийн хавсарга болгон үзэж байна. Фань Вэньлань «Хятадын ерөнхий түүх» зохиолдоо: «одоогийн Хятадын өргөн уудам хил хязгаарын анхны суурь довжоо» нь Баруун Хан улсын үед тавигдсан гэж түүхийн баримтыг мушгин гуйвуулаад, түүнд тэр үеийн Хятадын өрнө, умард этгээд дэхь бүх ястан захирагдаж байсан мэтээр үнэн байдалтай үл нийцэх санааг уншигчдад төрүүлэхийг эр- мэлзсэн байна.<sup>1</sup>

Хятадад хэвлэгдсэн өөр нэг номд өгүүлэхдээ: «манай улс бол олон үндэстнээс бүрэлдсэн нэгдмэл улс мөн. Монгол ястнууд эрт дээр үеэс манай орны умард этгээдэд оршин суусаар ирлээ. Монголын ард түмний түүх бол Хятадын түүхийн бүрэлдэхүүн хэсэг мөн»<sup>2</sup> гэсэн байна.

Төв Азийн олон ард түмний улс төрийн түүхийн тухайд гэвэл, эдгээр нь хэзээ ямагт амьдрах чадалтайгаа харуулж түүхийн үйл явцад идэвхтэй оролцож явлаа. Тэдгээрийн төр улсын түүх хэдэн зуун жилийн тэртээгээс сурвалж авчээ. Бүр манай эриний өмнөх 209 онд Цинь хэмээх хятадын анхны эзэнт улс байгуулагдсаны дараахан Хүннү нарын тал нутгийн их эзэнт гүрэн үүсч, түүхэнд тод томруун ул мөрөө үлдээсэн ба хятадын эзэнт гүрэнтэй амжилттай өрсөлдөж түүнийг багагүй сандарган түгшүүлж байжээ. Манай эриний өмнөх 198 онд хан овогтны Хятад улс арга буюу хүннү нарын эзэнт гүрэнтэй гэрээ байгуулан тусгаар тогтнолыг нь хүлээн зөвшөөрөхөд хүрч байжээ.

Хятад руу нүүдэлчдийн явуулж байсан аян дайны муу үр дагаварыг тэмдэглэхийн хамт, тэд олон зуун жилийн турш гадаадын эзлэн түрэмгийлэгчид юуны өмнө хятадын ноёлогчдоос өөрийн тусгаар тогтнол, газар шороо, гарал үүслийн нийтлэг шинж чанараа хамгаалж чадсаныг

<sup>1</sup>Фань Вэньлань. Дээр иш татсан зохиол. Боть I, 101—102, 105-р тал.

<sup>2</sup>Монгол ястнуудын товч түүх. (хятад хэлээр). Хөх хот. 1977, 1-р тал.

мөн анхаарч үзэх нь чухал юм. Хятадын эрх баригчид тухайлбал, Тан угсааныхны хаан төрийн (618-907) булаан эзлэх бодлогын эсрэг нүүдлийн ард түмний явуулж байсан баатарлаг тэмцлийн тухай бичээс бүхий хөшөө дурсгал Монголын нутаг дэвсгэр дээр цөөнгүй байдаг билээ. Үүнд эртний түрэгийн хөшөө дурсгалын бичээсүүдийг юуны өмнө дурдах хэрэгтэй. Кюльтегиний (685-731) алдар гавьяаг магтсан хөшөөний бага «бичээс» дээр ингэж сийлсэн нь: «Өдий их алт мөнгө, архи сархад, торго дурданг хэмжээгүй түгээн өгдөг табгач (хятад) ардуудын үг хэл нь хэзээд нялуун, эрдэнэс нь өнгөлөг зөөлөн (өөрөөр хэлбэл) үзэсгэлэнт сайхан, сэтгэл булаам байдаг. Тэд нялуун хэл ам, үзэсгэлэнт сайхан эрдэнэсээрээ алсад орших ардуудыг биедээ ихээхэн татах ажээ. Тэрхүү ардууд ойртон очиж суусаар эцэстээ тэнд муу санаа өвөрлөж сурна. Харин шудрага сайн, ухаалаг хүмүүс ариун сэтгэлт баатруудыг энэ табгач ардууд ба тэдний талынхан зөв замаас нь буруулуулж чаддаггүй байжээ»<sup>3</sup> гэсэн билээ.

### **3. Монголын феодалуудын булаан эзлэх дайныг, шагшин магтаж түүхийн үнэнийг гуйвуулж байгаа нь**

Хятадын түүхчид өөрсдийн удирдлагын эзэрхийлэн түрэмгийлэх бодлогын ашиг тусын тулд зөвхөн хятадын эзэн хаадыг төдийгүй мөн монголын болон бусад булаан эзлэгчдийг илэн далангүй зөвтгөн тахин шүтэцгээж байна. Тэд Чингис хааны байлдан дагууллыг «дэвшилттэй» юм, учир нь «монголчуудын ноёрхлын үед л зөвхөн Памирын уулсаас дорно, өрнөдөд орших олон улсын эрдэмтэд нь хятадын философи, утга зохиол. урлаг судлах аятай сайхан боломжтой болов<sup>4</sup> гэж бичсэн байна. «Жэньминь жибао» сонинд өгүүлэхдээ «Чингис хааны угсааныхны хаанчлал хятадын түүхэнд дэвшилттэй... Чингис хаан үндэстнүүдийн хоорондох зааг, хил хязгаарыг эвдэлж Хан, Тан угсааныхны хаанчлалын үеэс үзэгдээгүй олон үндэстний агуу их улсаа дахин сэргээн босгосон юм»<sup>5</sup> гэжээ. Хятадын Коммунист намын энэхүү төв хэвлэл Газрын Дундад тэнгис хүртлэх монголчуудын байлдан дагуулсан бүх газрыг хятадын эзэнт гүрний бүрэлдэхүүнд оруулсан байна. 1962 оны 1-р сард «Гуанмин жибао» сонинд бичсэн нь «Хубилай хаан манай олон үндэстний улсын хөгжилд гайхамшигтай хувь нэмэр оруулсан юм»<sup>6</sup> гэжээ. Хятадын түүхчдэд чиглэл өгөх зорилгоор 1960 хэдэн онд бичигдсэн энэхүү өгүүллүүдээс өмнөхөн хятадын түүхийн зохиолуудад Хятад ба бусад орнуудад тогтоосон монголын ноёрхлыг харийн булаан эзлэгчдийн байлдан дагууллын үе гэж шинжлэх ухааны үүднээс нэг саналтай зөв зүйтэй үзэж байсан явдал нийтэд мэдээж билээ. Гэтэл өнөөдөр хятадын маоист түүхчид нь Бээжингийн эрх баригчдын улам гүнзгийрсээр буй их гүрний дээрэнгүй үзэл, илэрхий эзэрхэг түрэмгий бодлогыг зөвтгөх гэж урьдаас баримталж ирсэн зарчмаас ухарч монголын байлдан дагууллыг магтах боллоо. Цю Шушэнь гэдэг нэг зохиогчийн бичсэн нь: «Монгол ястан бол хятадын үндэстний цөөнх мөн. Монголчуудын өвөг дээдэс хятадын газар шороон дээр аж төрж, амьдарч, өсч өөдөлж ирсэн юм. Чингис хаан бол монгол хаан, гэхдээ тэрээр Хятадын эртний олон үндэстний цөөнхийн нэгийг нь төлөөлөн төрийн эрхэнд (хятадын) гарсан хаан юм.

<sup>3</sup>С. Е. Малов. Памятники древнетюркской письменности. Тексты и исследования. М. Л., 1951. 34-р тал.

<sup>4</sup>«Лиши яньцзю», 1961. №: 2 38-р тал.

<sup>5</sup>«Жэньминь жибао», 1961 оны 8-р сарын 10.

<sup>6</sup>«Гуанмин жибао», 1962 оны 1-р сарын 21.

Оршин амьдарч ирсэн түүхийн бүх үеийн туршид нь монголчуудыг харийн улс гэж үзэж хэрхэвч болохгүй»<sup>7</sup> гэжээ.

Монголын ард түмний түүхийг хүчээр мушгин гуйвуулсан, үнэхээр эрээ цээрээ барсан иймэрхүү үгийг хятадын түүхчид «соёлын хувьсгалын» үедээ бус харин одоо хэлж байгаа юм. Хятадын эрх баригчдын ноёлох үзэлд сохроор хөтлөгдсөн энэ зохиогч дэлхийн социалист гэр бүлийн эрх тэгш гишүүн болох БНМАУ-ын ард түмний түүхийг ийнхүү бүдүүлгээр завхруулан тэдгээрийг төрсөн эх нутгаас нь өнчрүүлэн салгах гэсэн ичгүүргүй санаархлаа төрийн хэвлэлдээ илэн далангүй илэрхийлэхээсээ өчүүхэн ч санаа нь зовсонгүй нь туйлын харамсалтай.

Маоист түүхчид өөрийн орны түүхийг ч мушгин гуйвуулж, харийн булаан эзлэгчдийн эсрэг хятадын ард түмний явуулсан эрх чөлөөний тэмцлийн баялаг уламжлалыг басамжлан доромжилж байна. Хятадад монгол хаадын байгуулсан Юан гүрэн бол, маоист түүхчдийн үздэгээр, «хятадын аугаа их нэгдлийн» буюу «хятадын олон үндэстний аугаа их гэр бүлийн бэхжилтийн» үе хэрхэвч биш, харин ч хятадын ард түмнийг монголын булаан эзлэгчид-феодалууд, тэдний холбоотон болж байсан хятадын цэрэг-феодалын түшмэдийн туйлын хүнд дарлал мөлжлөгийн аюултай бэрх үе байсныг түүх нэгэнт аль хэдийнээ нотлон өгсөн билээ.

#### **4. Манж Чин улсын түүхийг завхруулж, монголын ард түмний үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолын тэмцлийг зэмлэн буруушааж байгаа нь**

Хятадын түүхчид монголын эзэн хаадын үйл ажиллагааг хэрхэн дүгнэдэг шигээ, Эеэр засагч, Энх Амгалан зэрэг манжийн байлдан дагуулагчдын булаан эзлэх дайны зорилгыг элдвээр гуйвуулан завхруулж бас л олон үндэстний Хятадыг нэгтгэхэд оруулсан «гавъяаг» нь шагшин магтаж байна. Тэд «нэг улсын нэгдмэл үндэстэн» хэмээх үхширмэл номлолоо баримтлан «хятад, манж нар угаас нэг гэр бүл» байсан мэт батлахыг оролдон манжийн байлдан дагуулагчдын газар дэвсгэрийн «өвийг» өвлөх эрхээ түүхийн үүднээс үндэслэх зорилго тавьж байна. Мөн тэд Манж Чин улсын доторхи олон ард түмэн мөнхийн найрамдалтай байсан мэтээр батлахыг мэрийж, тэр үед Хятадын нийгмийн гол зөрчил нь хятадын дотоод ангийн ба үндэсний зөрчил бус, харин хятад ба империализмын хоорондох зөрчил байсан мэтээр бичиж байна.

Хятадын түүхчид нь манжийн байлдан дагуулал эхлэхээс өмнө Монгол, Зүүнгар, Дорнод Туркестан, Түвд болон бусад орнууд биеэ даасан тусгаар байдалтай байсан баримтыг үгүйсгэж, эдгээр орны эсрэг манжийн эрх баригчдын явуулсан цуст байлдан дагуулалыг бүрэн зөвтгөсөн төдийгүй, манжийн ноёрхлыг эсэргүүцсэн ард түмний эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө хөдөлгөөнийг «хагалан бутаргах үйл ажиллагаа» гэх зэргээр буруутгаж, тэрхүү хөдөлгөөний удирдагчдад нь «Хятадын үндэсний эрх ашгаас тэрслэгчид», «эх орноосоо урвагчид» гэсэн сэтэр зүүлгэж байна. Жишээ нь «Лиши яньцзю» сэтгүүлийн нэг дугаарт бичсэн нь: «Зүүнгар аймаг хэзээ ч тусгаар улс байсангүй, харин Хятадын төв засгийн газарт захирагдаж явжээ. XVII зууны эхэнд Зүүнгар ийм л хэвээр үлдсэн юм»<sup>8</sup> гэжээ. «Зүүнгарын хагалан бутаргах үйл ажиллагааг Чин улсын засгийн газар тас цохисон явдал Хятадын дотоод хэрэг байсан бөгөөд нэг улс нөгөөгөө эзлэхтэй огт адилгүй хэрэг юм»<sup>9</sup> гэж мөн сэтгүүлд бас тэмдэглэсэн байна. Цааш нь тэрхүү сэтгүүлд үргэлжлүүлэн

<sup>7</sup>Цю Шушэнь. Чингис хааныг үнэлэх зарим асуудалд. «Гуанмин жибао», 1979 оны 9-р сарын 11.

<sup>8</sup>«Лиши яньцзю», 1976. № 2. 102-р тал.

<sup>9</sup>Мөн тэнд. 109-р тал.

өгүүлснээс үзвэл, «Манай орны баруун хязгаарт Галдан, Цэвээнравдан, Амарсанаагаар толгойлуулсан Зүүн гарын цөөн хэсэг язгууртнууд бол нэг ястны л доторхи хагалан бутаргагчид байв. Тэд Хаант Оросын тусламжтайгаар алс тэр хязгаартаа бослого гаргаж эх орноосоо тасран салах этгээд болж, урван тэрсэлж олон ястан ард түмэнд хор хөнөөл учруулж төр улсынхаа нэгдлийг эвдлэн сүйрүүлэв»<sup>10</sup> гэжээ.

Ши Юйсинь гэгч нэг этгээд 1974 оны «Лиши яньцзю» сэтгүүлийн эхний дугаарт бичсэн нэг өгүүлэлдээ Ойрдын Зүүнгарын хаант улсын тогтнож байсан баримтыг «зөвлөлтийн ревизионистуудын дэмийрэл» гэж үгүйсгэн үзээд, «ойрдууд бол манай орны олон ард түмний нэг болох монголчуудын салбар мөн» бөгөөд Мин, Чин улсын эзэн хаадаас язгууртны хэргэм тушаал хүртэж явсан юм гэсэн байх юм. Түүний цааш нь бичсэн нь: «1677 онд Зүүнгарын монгол-ойрадын захирагч Галдан өөрийгөө хаан гэж зарлаад дур зоргоороо аашлах болов. Үүний дараа Зүүнгарын захирагчид заримдаа Чин улсад захирагдаж заримдаа түүнээс тэрсэлж цаг ямагт эх орноо бутарган сарниулах оролдлого хийж явжээ»<sup>11</sup> гэсэн байна. Лю Данянь Энх Амгалангийн тухай» өгүүлэлдээ Түвд, Манжуур, Монголыг хятадын үндэсний цөөнхүүд оршин суудаг газар нутаг гэж зарласан байна. Тэрээр бичихдээ Энх Амгалан хаан «гурван удаа Галданы эсрэг аян дайн хийсэн», «Түвдийг дахин нэгтгэсэн», «манж үндэстэн бол хятадын үндэсний цөөнхүүдийн нэг боловч цөөн тоотой, хан овогтныг бодвол эдийн засгаар хоцрогдсон» гэх мэтээр дурдсан байна. Түүний бас өгүүлсэн нь: «Энх Амгалан тэргүүлэн Чин улсын анхны хаадын үеийн хаанчлалын үед хятадын олон янзын ястнуудыг хан үндэстний ивээл дор нийтээр нь нэгтгэх нөхцөл бүрэн бүрэлдэв» гэжээ. Энэ зохиогч дээрх санаагаа лавшруулан цааш нь бичихдээ, «Энх Амгалан бүх орноо нэгтгэсэн явдлыг бусад ястнуудын газар нутгийг булаан авсан түрэмгийлэл хийсэн гэх буюу, эсвэл тэднийг байлдан дагуулсан гэх нь...» буруу гэж хэлсэн байна.<sup>12</sup>

Төв Азийн түүхэнд мэдэгдэхүйн үүрэг гүйцэтгэж, тусгаар тогтнож байсан Зүүнгарын хаант улсын бүх түүх нь хятадын түүхчдын санаанаасаа гаргасан худал хуурмаг, болчимгүй дүгнэлтийг бүрэн няцааж байгаа юм. Бид энэ асуудлыг энд тодорхой авч хэлэлцэхгүй, учир нь монголын ард түмнүүдийн баатарлаг тэмцлийн жинхэнэ үнэн түүх монгол, зөвлөлтийн эрдэмтдийн зохиолуудад бүх талаар тодорхой бичигдсэн юм.<sup>13</sup>

Түүхийн чухамхүү үнэнийг авч үзвэл манжийн байлдан дагуулал, ноёрхол нь эзлэгдсэн орнууд, түүний дотор хятадын өөрийн түүхэнд хүнд бэрх үе болсон юм. Манж Чин гүрэн, маогийнхны үздэгээр, хятадын аль нэг ястан нөгөөгөө «энх тайвнаар», «ээлжлэн» халж хятадын төрийн эрхэнд гарч байсныг харуулж байгаа хэрэг ерөөс биш, харин тэр гүрэн нь гарал үүслээрээ хятадаас огт өөр ялгаатайгаар үл барам хята-

10Мөн тэнд. 110-р тал.

«Лиши яньцзю», № 1. 1974. 120-р тал.

Лю Данянь. О. Кавси—«Лиши яньцзю», 1961. № 3. «Историческая наука в КНР». Отв. ред. Р. В. Вяткин. Н. П. Свистунова. М., 1971. 163-р тал Ши Да. Хятадын эсрэг Хаант Оросын явуулсан түрэмгийллийн товч түүх», Бээжин. 1976. хятад хэлээр; БНХАУ-ын ГЯЯ-ны баримт бичгүүд. 1969. «БНМАУ-ын түүх»; УБ., 1967; «БНМАУ-ын түүх», боть 2. УБ., 1968 Ш. Нацагдорж. Халхын түүх. УБ., 1963; Б. Баянчуулган. Манжийн ноёрхолын үеийн түүхийн материалууд. УБ., 1936; Н. Ишжамц. Монголын ард түмний 1755—1758 оны тусгаар тогтнолын зэвсэгт тэмцэл. (Амарсанаа, Чингүнжав нарын бослого). УБ., 1962. Д. Гонгор. Ховдын хураангуй түүх. УБ, 1964 И. Я. Златкин «История Джунгарского ханства» (1635--1758). М., 1964.

дын зүүн хойд этгээдэд улс төрийн биеэ даасан хүчин байсан манж ястны дотроос гарсан эрх баригчдын олон жилээр явуулсан цуст байлдан дагууллын үр дүнд байгуулагдсан билээ. Хятадын тухайд гэвэл тус улс өөрөө мөн харийн булаан эзлэгчид манж нарын идэш болсон билээ. Манжийн булаан эзлэгчдийн явуулсан дайны явцад олон зуун мянган хятадууд, монгол, уйгур болон бусад ард түмнийг хайр найргүй хяджээ.

Манжийн хаад Монголд 1691-1911 он хүртэл ноёрхон байх завсраа монголын ард түмнийг мөн л хатуу ширүүнээр дарлан мөлжиж тус орныг тонон дээрэмдэх бодлого явуулж байсан билээ.

Монгол оронд тогтоосон манжийн ноёрхлын нэг хортой уршиг нь тус оронд хятадын мөнгө хүүлэх капитал нэвтэрч ардын аж ахуйг дааж давшгүй өрөнд унагасан явдал мөн.

Манжийн колоничлолын дэглэм нь монголын ард түмнээс харийн булаан эзлэгчдийн улс төр, эдийн засгийн хүчирхийллийн эсрэг гаргасан аливаа дургүйцэл зсэргүүцлийг харгислан дарж байжээ. Гэвч монголын ард түмэн бууж сөгдөж өгсөнгүй, манжийн ноёрхлын эсрэг дахин дахин босож тэмцэж явжээ.

Манжийн эзэнт гүрэн манжийн ноёрхлыг эсэргүүцэн боссон хятад, монгол болон бусад ард түмний үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний үр дүнд 1911 онд устгагдсан нь нийтэд мэдээж хэрэг билээ. Гэтэл одоогийн хятадын түүхчид түүхийн энэ үзтэл тодорхой баримтыг элдвээр мэтгэн маргаж манжийн төрийг хятадын төр мэт үзэж байгаа нь угтаа Бээжин манжийн байлдан дагуулагчдын «түүхэн» өвийг залгамжлах эрхийг өөртөө үлдээх гэсэн оролдлоготой нь холбоотой юм. Хятадын түүхчид чухамхүү ийм санаа баримталж манжийн дарлал мөлжлөгийн эсрэг ард түмнүүдийн явуулсан үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний түүхийг гүтгэн гуйвуулж байна. Ийнхүү «Хятадын эсрэг Хаант Оросын явуулсан түрэмгийллийн товч түүх» хэмээх номд манжийг эсэргүүцсэн монголын ард түмний 1911-1912 оны тэмцлийн тухай буруу дүгнэн бичсэн байна. Монгол орон 1911 онд тусгаар тогтнолоо зарласан явдлыг Хаант Оросоос «өөрийн хил хязгаарыг манай улсын Их хэрмийн хормой хүртэл тэлэхийг» эрмэлзсэн «өдөөн хатгах бодлого»<sup>14</sup> гэж мөн номонд бичсэн нь Монгол орныг хэзээнээс хятадын хэсэг мэт үзэж, манай БНМАУ-ын газар дэвсгэрт өнгөлзөж байгаагаа «түүхийн үүднээс» нотлохыг арчаагүй оролдож байгаагийн гэрч даруй мөн.

Монголын ард түмний 1911-1912 оны үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолын хөдөлгөөний түүхийн талаар дэлгэрэнгүй өгүүлэх шаардлага алга байна. Учир нь тэрхүү түүхийг монгол-зөвлөлтийн түүхчид гүнзгийрүүлэн судлаж олон бүтээл хэвлэн нийтэлснийг уншигчид хялбархан олж үзэж болно.<sup>15</sup>

<sup>14</sup>Хятадын эсрэг Хаант Оросын явуулсан түрэмгийллийн товч түүх. Бээжин., 1976, 73—74-р тал. (Хятад хэл дээр), Мөн үз. Монгол ястны товч түүх, хамтын бүтээл, Хөх хот., 1977. 90—94-р тал. (хятад хэлээр). Үз.; «Дэлхийн газрын зураг», Бээжин., 1972 он.

<sup>15</sup>БНМАУ-ын түүх, нэгэн боть (монгол хэлээр). 2 дахь хэвлэл. УБ., 1966. БНМАУ-ын түүх. гурван боть. II боть УБ., 1968. (монгол хэлээр). Ш. Сандаг Монголын улс төрийн гадаад харилцаа, 1850—1919. 2 дэвтэр. Нэгдүгээр дэвтэр. Монголд манжийн ноёрхлыг устгаж үндэснийхээ тусгаар тогтнолыг сэргээн тунхагласан нь, 1850--1911. УБ.. 1971. Ш. Бира. Н. Ишжамц XIX зууны эцэс XX зууны эхний монголын үндэсний эрх чөлөө тусгаар тогтнолын хөдөлгөөн. Түүхийн шинжлэх ухааны олон улсын хурал дээр тавьсан илтгэл. Сан-Франциско. 1975 оны 8-р сар. УБ, (англи, орос хэлээр). Ш. Сандаг. Түүхэн тэмцлийн ялалт. Монголын үндэсний тусгаар тогтнолыг сэргээн тунхагласны 70 жилийн ойд «Үнэн», 1981. XII. 1.

Гагцхүү тэмдэглэх нь, 1911-1912 оны хөдөлгөөний ач холбогдол бол Монголд 200 гаруй жил ноёрхсон манжийн колоничлолын дэглэмийг түлхэн унагаж, Монголын үндэсний тусгаар тогтнолыг сэргээн тунхагласанд оршино. Энэ тухай Ю.Цэдэнбал бичихдээ: «Монголын үндэсний улс сэргэн байгуулагдсан нь хэдүйгээр феодалын ангийн чанартай байлаа ч гэсэн тус орны түүхэнд гарсан нэлээд дэвшилтэт үзэгдэл мөнийн учир гэвэл, монгол орныг гадаад ертөнцөөс зориуд тасархай барьж байсныг арилгаж, монголын ард түмний эрх чөлөөний тэмцлийг Орос, хятадын ард түмний хувьсгалт хөдөлгөөнтэй холбон зузаатгах нөхцөл бүрэлдүүлэв»<sup>16</sup> гэжээ.

1911 оны 12-р сарын 1-нд Их Хүрээнд монголын төрийн тусгаар тогтнолыг Богд хаант Монгол улсын хэлбэрээр сэргээн босгосон тухай тунхагийг зарлан нийтлэв.

Тэр цагаас хойш 70 жил өнгөрлөө. Энэ тэмдэглэлт өдөр бол монголын ард түмний үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө тэмцлийн түүхийн нэгэн яруу сайхан хуудас мөн.

### **5. БНМАУ-ын шинэхэн түүх ба одоогийн социалист байгуулалтыг гүтгэн дайрч байгаа талаар**

Аугаа их Октябрийн социалист хувьсгал хүн төрөлхтний түүхэнд цоо шинэ үеийг нээж, дэлхийн пролетари нарын хөдөлгөөнийг колони ба хагас колонийн үгээгүйчүүд хөдөлмөрчдийн тэмцэлтэй холбосон нөхцөлд монголын ард түмний эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө тэмцэл сая амжилтанд хүрэх бүрэн бололцоотой болсон билээ. Оросын хувьсгалт пролетари нар, Зөвлөлт Орос улс нь монголын ард түмний чин үнэнч аугаа их хань, үнэнч холбоотон нь болсон юм. Зөвлөлт засгаас 1919 оны 8-р сард монголын ард түмэн Гадаад Монголын засгийн газарт явуулсан илгээлтэд өгүүлсэн нь: «Зөвлөлт засаг дахин баяртай мэдэгдэх нь: Оросын ард түмэн, Япон, хятадын засгийн газартай монголын талаар байгуулсан бүх гэрээ хэлэлцээрээс татгалзав. Монгол бол эрх чөлөөтэй орон мөн. Оросын зөвлөхүүд, хаант засгийн консулууд, банкны эзэд, баячуул монголын ард түмнийг хүч түрэн алт мөнгөөр гартаа атгаж байсан эд нар цөм Монголоос зайлах ёстой. Гадаадын нэг ч хүн монголын дотоод хэрэгт оролцох эрхгүй, тус орны бүх эрх, хууль цааз монголын ард түмнийх байх ёстой. 1913 онц хэлэлцээрийг өөрчлөн Монгол тусгаар тогтносон орны хувьд Бээжин, Петроградаас хамаарахгүйгээр бусад ард түмэнтэй шууд харилцах эрхтэй гэжээ.

Зөвлөлт Орос улс анхныхаа өдрөөс эхлэн урьдын хаант засгийн байгуулсан бүх тэгш бус гэрээ хэлэлцээрүүд, түүний дотор монголын талаар Хятадтай байгуулсан Хиагтын гурван улсын гэрээ зэргийг цуцалж, Монголын тусгаар тогтнол, монголын ард түмний үндэсний эрх ашгийг гүнээ хүндэтгэн үзэж байсан нь тодорхой билээ.

Мао Цэдуну зохиолуудыг шинжлэж үзвэл, Монголыг их л «анхаарч» байсан нь түүний үндэсний дээрэнгүй ноёлох үзлээс хэтэрсэнгүй. Хятадын ард түмний хувьсгалт тэмцэлд нь тал бүрийн тусламж үзүүлж байсан монголын ард түмэн, манай улсын талаар бодитой сайн санааны үг түүний зохиолуудад ер байдаггүй нь тэмдэглүүштэй юм. Мөн Мао Цэдун нь үндэстнүүдийн өөрөө тогтнох эрхийн тухай, урьд хоцрогдсон орнууд капиталист бус буюу социалист чиг баримжаагаар хөгжиж болох тухай Лениний сургаал болон эл сургаалыг дэлхийн олон

<sup>16</sup>Ю. Цэдэнбал. Из истории развития и укрепления нерушимой дружбы монгольского и китайского народов.—«Вспросы истории», 1959 № 9.

ард түмэн хэрэгжүүлэн биелүүлж байгаа явдлыг огтхон ч ойшоон анхааран үздэггүй байв.

Мао Цзэдун анхнаасаа Монголын эсрэг байр суурь баримталж байжээ. Бүр 1936 онд Мао Цзэдун америкийн сурвалжлагч Эдгар Сноутай ярилцахдаа: «Хятадад ардын хувьсгал ялсан цагт Гадаад Монгол аяндаа, өөрийнхөө хүсэлтээр Хятадын холбооны улсын хэсэг болно»<sup>17</sup> гэсэн байдаг.

Мао Цзэдун 1949 оны 2-р сард Зөвлөлт Холбоот Улсын удирдагчдад хандаж БНМАУ-ыг Хятадад нэгтгэх талаар юу гэж бодож байгааг нь асууж лавлаж байжээ. Үүний хариуд И. В. Сталин хэлэхдээ, Зөвлөлт Холбоот Улсын удирдагчид нь Бүгд Найрамдах Монгол Ард Улс Хятад улсын харьяат автономи болох юм уу, бүр бүх монгол районууд нэгэн автономи байгуулалд нэгдэх замаар өөрийн тусгаар тогтнолоосоо татгалзахгүй байх гэж бодож байгаа ба энэ талаар шийдвэрлэх үгээ БНМАУ өөрөө хэлэх буйзаа гэжээ.

БНХАУ, БНМАУ-тай дипломат харилцаа тогтоосны дараа ч Мао Цзэдун ба түүний шадар этгээдүүд БНМАУ-ыг залгих санаархлаа огтхон ч орхиогүй юм. БНХАУ-ыг тунхагласны таван жилийн ойгоор 1954 онд Бээжинд зөвлөлтийн төлөөлөгчид байх үеэр хятадын эрх баригчид их гүрний дээрэнгүй үзлээ цухалзуулж. Зөвлөлт Холбоот Улсын удирдагчидтай БНМАУ-ыг Хятадад нэгтгэн нийлүүлэх талаар «тохиролцох» санал тавьж байжээ. Тэр үед Зөвлөлт Холбоот Улсын удирдагчид хятадын эрх баригчидтай энэ асуудлыг хэлэлцэхийг татгалзаж, БНМАУ-ын хувь заяаг Бээжин, Москвад биш харин Улаанбаатарт шийдвэрлэнэ гэдгийг эрс шийдвэртэй мэдэгдсэн билээ.

Бээжингийн эрх баригчид И. В. Сталиныг тахин шүтэж байсан явдлыг шүүмжилсэн шүүмжлэлийг ашиглан БНМАУ-ыг булаан авахад чиглэсэн өөрсдийн оролдлогоо дахин гаргаж байсан юм. Тэд зөвлөлтийн удирдагчдад хэлэхдээ ганц хүнийг тахин шүтэх явдлын нэг уршиг нь И. В. Сталин Монголыг Хятадтай нэгтгэхийг зөвшөөрдөггүй байсанд оршиж байсан юм гэжээ. Чингэхдээ тэд Монголыг Тайваны адил үзэж, Монголыг Хятадад нэгтгэх ёстой гэдгээ илэрхийлжээ.

Үүний хариуд зөвлөлтийн удирдагчид зарчмын үүднээс мэдэгдэхдээ, И. В. Сталины үйл ажиллагааны зөвхөн алдаатай талуудыг шүүмжлэсэн болохоос биш, БНМАУ-ын талаар түүний баримталж байсан байр суурь зөв бөгөөд үүнийг хянан өөрчлөх шаардлагагүй гэжээ. Мөн түүнчилэн Монгол, Тайвань хоёрыг адилтган үзэж болохгүй, учир нь Тайваньд хятадууд оршин суудаг, Монголд монголчууд оршин суудаг, Монгол бол тусгаар тогтносон улс мөн бөгөөд бүр хуучин төрийн үед ч Хятадын харъяанд орж байсан удаагүй юм гэдгийг зөвлөлтийн тал яруу тод мэдэгджээ.

1964 оны 7-р сард Мао Цзэдун БНМАУ-ыг Хятадад нэгтгэх ёстой гэсэн улиг домог болсон асуудлыг дахин тавьсан юм. Үүнд Мао Цзэдун Монголыг «колоничилж» өөрийн «Колони» болгов гэх мэтээр Зөвлөлт Холбоот Улсыг ямар ч үндэсгүй гүтгэн хараан зүхэж билээ.

Маогийнхан БНМАУ-ын капиталист бус хөгжлийн зам, түүний түүхэн туршлага, олон улсын ач холбогдлыг нь бас гүтгэн дайрч байв. Маогийнхан 1960-аад оноос манай капиталист бус хөгжлийн туршлагыг гүжирдсэн өгүүллүүдийг олноор нийтлэж эхлэв. Жишээ нь, «Жэньминь жибао» сонинд Монгол бол Зөвлөлт Холбоот Улсын «колони» болон ху- вирав. Түүний капиталист бус хөгжлийн туршлага «бүрэн нурав», энэ

«туршлага» нь «Ази, Африк, Латин Америкийн ард түмэнд муу жишээ болж байна» гэх мэтээр илт гүжирдэн дайрч байв.

Хөгжиж байгаа олонхи орнууд, ялангуяа социалист чиг баримжаатай орнуудын улс төрийн зүтгэлтнүүд нь монголын ард түмний капиталист бус хөгжлийн түүхэн туршлагын ач холбогдлыг зохих ёсоор өндрөөр үнэлж энэ талаар бээжингийнхний гүтгэлэг, хараал зүхлийг бүрэн няцааж байна. МАХН-ын XVII их хурал дээр 1976 оны 6-р сард Иракийн төлөөлөгч, Иракийн Коммунист намын Улс төрийн товчооны гишүүн нөхөр Захи Хари Сагийд хэлэхдээ, «Танай их хуралд оролцохоор уригдаж, та бүхний сонин туршлагатай танилцаж байгаадаа Иракийн коммунист нам бахархан баярлаж байна. Та бүхэн хувьсгалын өмнө ихэд хоцрогдсон Монгол оронд орчин үеийн пролетари нарын олон улсын сургаал-марксизм-ленинизмийг зөв бүтээлчээр хэрэглэжээ. Үүгээрээ та бүхэн Маркс, Энгельс, Лениний ялгуусан хүчирхэг сургаалын бат орших чадвар, шинжлэх ухааны коммунизмын дэлхий дахины ач нөлөөг дахин хурц тод харуулж, улмаар шинжлэх ухааны эрдэнэсийн санг баяжуулсан юм... ЗХУ, ЗХУКН-тай звдэршгүй бат бэх холбоотой байх явдал бол гол хувьсгалч хүчин зүйл мөн гэдгийг танай үлгэр дууриал бидэнд сургаж байна. Гагцхүү ийм замаар замнавал бид үндэсний тусгаар тогтнолоо бэхжүүлж, социалист чиг шугамыг барьж, капиталист биш хөгжлийн замд орж чадах юм»<sup>18</sup> гэжээ.

Мөн өөр нэг жишээ дурдаж болно. Афганистаны ардын Ардчилсан намын Ерөнхий нарийн бичгийн дарга БНААфГУ-ын Хувьсгалт Зөвлөлийн дарга, Ерөнхий сайд Бабрак Кармаль 1980 оны 2-р сард өгүүлэхдээ, «Бид үндэсний асуудал, соёлын хувьсгалын асуудлыг шийдвэрлэхдээ капиталист нийгмийг алгасаж феодализмаас социализмд шилжин орох явцад өөрийн эдийн засгаа амжилттай өөрчилсөн Монголын туршлаганд түшиглэдэг юм»<sup>19</sup> гэжээ.

Маогийнхан БНМАУ-ын социалист байгуулал ба Зөвлөлт Холбоот Улс болон социалист бусад орнуудтай тогтоосон ах дүүгийн найрамдал, хамтын ажиллагааг ч гэсэн мөн л дутахгүй гүжирмэгээр гүтгэж байв. «Жэньминь жибао» соин бичихдээ, БНМАУ «зөвлөлтийн ревизионистуудын колони» болж үүний уршгаар «тус орны эдийн засагт нь хэмжээлшгүй их хохирол учрав»<sup>20</sup>, «Монголд үйлдвэр байхгүй»<sup>21</sup>, «мал сүрэг нь жилээс жилд хорогдсоор байна»<sup>22</sup>, «Монголын ард түмэн хятадын соёлын хувьсгалд баяр хүргэж Монголдоо хоёр дахь хувьсгал хийхэд амь насаа хайрлахгүй зүтгэхэд бэлхэн байна»<sup>23</sup> гэх мэтээр дайрч давшилж байсан билээ. Үнэн байдалд огт үл нийцэх иймэрхүү хараал зүхлийн үгээр дүүрсэн зүйлийг маогийнхан «соёлын хувьсгалын» эмгэнэлт үедээ бичиж байсныг дахин санаж үзэх шаардлагагүй мэт бодогдож болно. Гэвч Бээжингийн одоогийн зрх баригчид Монголын эсрэг, Зөвлөлтийн эсрэг, социализмын эсрэг бодлого, хорт явууллагаасаа огтхон ч няцаагүй хэвээр байгаа юм. Гагцхүү тэдгээрийн дайсагнасан бодлого, үйлдэл нь зөвхөн арга хэлбэрийн хувьд «соёлын хувьсгалын» үеийнхээсээ өөр болсонд бид хууртагдаж болохгүй нь мэдээж хэрэг.

Монгол Ардын Хувьсгалт Намын XVII их хурал, Дэлгэрэнгүй тайлан. УБ., 1976. 292—293-р тал  
«Новости Монголии», 1980 оны 2-р сарын 18.

«Жэньминь жибао», 1967 оны 7-р сарын 10, 1969 оны 5-р сарын 27.

Мөн тэнд.

Газрын зураг. Бээжин., 1972. 11-р тал.

«Жэньминь жибао», 1969 оны 5-р сарын 27.

Одоо үед маогийнхан эзэрхийлэн түрэмгийлэх, ноёлох алсын төлөвлөгөөгөө хэрэгжүүлэхийн тулд юуны өмнө айл хөрш орнуудын доторхи эх оронч бус, тусгаарлах бодлоготой, жижиг хөрөнгөтний зүсэн бүрийн үндсэрхэг үзэлтнүүд улс төрийн талаар тогтворгүй, хөнгөн хийсвэр этгээдүүдийг хүртэл овжин ашиглан өөрсдийн хорт үзэл суртлаа тарааж, хорлон сүйтгэх үйл ажиллагаагаа явуулахыг чармайсаар байна. Хятадад улс орны түүх, түүний дотор БНМАУ-ын түүхийн бүх үеийг гуйвуулан завхруулах зорилгоор бичигдсэн ном зохиол сүүлийн үед бүр ч олширсоор байна.

Бээжингийн удирдлага урьдын адил, БНМАУ-ын газар нутагт шунахайран булаан эзлэх хоосон санаархлаа тавиагүй, манай улсын дархан хилийн дагуу түгшүүр бий болгож хорлон сүйтгэх үйл явууллага хийж түүний дотоод хэрэгт хөндлөнгөөс оролцохыг оролдолхийлсоор байна. Одоо монгол-хятадын хил дагуу хятадын үлэмж олон цэргийн хүч бөөг-нөрч байна. ЗХУ, БНМАУ-тай хил залгаа хятадын нутаг дэвсгэрт БНМАУ-ын цэргийн дөрвөн тойрог, түүний дотор, Бээжин, Шэньяны хамгийн том хоёр тойргийн цэрэг бөөгнөрсөн байна. Сүүлийн хоёр тойрогт хятадын хуягт танкийн дивиз, нисэх хүчний нь талаас ихэнхи хучь байдаг билээ. Гадаадын мэдээнээс үзвэл, БНМАУ ба ЗХУ-тай залгаа хятадын хил дээр 2 сая 400 мянган цэрэг буюу одоо байгаа хятадын зэвсэгт хүчний ихэнхи нь цугларчээ.

Ийм түгшүүртэй нөхцөл байдалд БНМАУ-ын засгийн газрыч хүсэлтээр тус орны нутагт байгаа зөвлөлтийн цэргийн ангиудыг гаргахыг удаа дараа шаардсан хятадын эрх баригчдын шаардлага нь хятадын зүгээс улам өсөн байгаа цэрэг дайны бодит аюул заналын өмнө манай орныг ямар ч хамгаалалтгүй болгох гэсэн оролдлого даруй мөн.

МАХН-ын Төв Хорооны Ерөнхий нарийн бичгийн дарга, БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн дарга Ю.Цэдэнбал 1979 оны 11 -р сарын 19-нд болсон МАХН-ын Төв Хорооны VI бүгд хурал дээр хэлсэн үгэндээ, «Монгол-Хятадын харилцааны хувьд бол, бид Хятадтай улс хоорондын харилцааг хэвийн болгохын төлөө гуйвалтгүй тэмцэж байна. Гэтэл манай энэ сайн санаа зоригийн эсрэг бээжингийнхэн дайсагнаж, эзлэн түрэмгийлэх их гүрний жанжлах чиг бодлогыг сэргүүлэн тавьж байна.

Хятадын эрх баригчид манай орны талаар ийм бодлого явуулж байгаа мөртлөө улс хоорондын гэрээний үндсэн дээр манай оронд байгаа зөвлөлтийн цэргийн армиудыг БНМАУ-ын нутаг дэвсгэрээс гаргахыг зүй бусаар шаардаж байна...

БНМАУ-ын тусгаар тогтнол, бүрэн эрхэнд, бээжингийн эрх баригчдын зүгээс бодитойгоор заналхийлж байгаа гэж шууд хэлж болно. Энэ аюул занал арилаагүй цагт бид өөрийн социалист эх орны тусгаар тогтнол аюулгүй байдлыг хамгаалах үйлсдээ урьдын адил Зөвлөлт Холбоот Улсын үр бүтээлтэй тусламжийг авах явдал зүй ёсны хэрэг юм»<sup>24</sup> гэжээ.

Хятадын талаар баримталж байгаа манай зарчимч байр суурь хэвээр байна. Энэ тухай МАХН-ын XVIII их хуралд нөхөр Ю.Цэдэнбалын тавьсан МАХН-ын Төв Хорооны тайлан илтгэлд тэмдэглэсэн нь: «Бүгд Найрамдах Хятад Ард Улстай харьцах тухайд бол уг харилгаа муудсан нь манай буруу биш юм. Үүний шалтгаан нь хятадын эрх баригчид социализмын зарчмыг мушгин гуйвуулж, улс хоорондын харилцааны хэм хэмжээг балмадаар алдагдуулан, тэдгээрийг их гүрний жанжлах үзэл, айлган сүрдүүлэх, тулган шахах бодлого үйлдлээр сольсонд

<sup>24</sup>Ю. Цэдэнбал. МАХН-ын Төв Хорооны VI бүгд хурал дээр хэлсэн үг «Үнэн»; 1979 оны 11-р сарын 20.

оршино. Тэд манай орныг эзлэн түрэмгийлэх төлөвлөгөөгөө хэрэгжүүлэхийг оролдохдоо түүх, бодит үнэнийг завхруулж, БНМАУ-ын эсрэг цэрэг дайны бэлтгэлийг ил хийж байна»<sup>25</sup> гэжээ.

## МАОИСТСКАЯ ФАЛЬСИФИКАЦИЯ ИСТОРИИ МНР И ИСТОРИЧЕСКАЯ ПРАВДА

### Р е з ю м е

Касаясь истории древних тюркских и монгольских народностей, авторы доказывают беспочвенность утверждения китайских историков о том, что эти народы всегда являлись национальными меньшинствами и всегда входили в состав «единого многонационального государства» Китая. В статье подчеркивается сагубытний характер общественно-политического и культурного развития кочевых народов, населявших территорию Монголии.

Китайские историки пытаются оправдать и идеализируют агрессивную политику китайских и монгольских завоевателей, в частности Чингис хана, считая его походы «прогрессивными» в истории Китая и других стран Азии. Цель такой фальсификации — оправдать претензии маоистов на «историческое «наследие» монгольских ханов-Чингиса, Хубилая и Других.

По мнению авторов статьи историческое «обоснование» китайскими историками «законных прав» Китая на «наследие» маньчжурских завоевателей-Шуньчжи, Канси и других, также не выдерживает никакой критики, а лишь выдает их экспансионистские намерения в отношении соседних стран.

Авторы считают, что как монгольские так и маньчжурские завоевания были тяжелейшим периодом в истории всех завоеванных народов.

В статье подчеркивается историческое значение антиманьчжурского национально-освободительного движения монгольского народа 1911-1912 гг., в результате которого было свергнуто двухсотлетнее господство Цинской династии в Монголии и восстановлена ее государственная независимость в форме Богдохаганской монархии (1911 -1919).

Особое место в статье отведено критике аннексионистской, двурушнической политики Мао Цзэдуна и его последователей в отношении МНР.

Извращение китайскими историками современной социалистической действительности Монголии и братской монголо-советской дружбы, как и антимонгльская политика Пекина, является составной частью его глобальной гегемонистской политики

Ю. Цэдэнбал. МАХН-ын XVIII их хурал дээр тавьсан Намын Төв Хорооны тайлан, ойрын жилүүдийн зорилт—«Үнэн», 1981 оны 5-р сарын 27.